



Орчин цагийн банкны тогтолцоо үүсч
бэхэжсэний 90 жилийн ойд зориулав



Шадав овогт Мажаагийн Сүхээ

1939 онд төрсөн. 1961 онд Санхүү эдийн засгийн техникумыг банкны нягтлан бодогч, 1969 онд МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр тус тус төгсгөсөн. 1961-1978 онд Улсын банкны Улаанбаатар хот, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн банкны конторт зээлийн ахлах эдийн засагч, конторын дарга, 1979-1991 онд УБЕХ-нд Боловсон хүчин захиргааны хэлтэс, Шалган байцаах хэлтсийн

дарга, 1991 онд Монголбанкны Мэдээлэл судалгааны хэлтсийн дарга, 1991 оноос Ардын банкинд тэргүүн дэд захирал, 2000 оноос Капитал банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

19 дүгээр зууны үеийн Монгол орны эдийн засгийн байдал

Банк байгуулах өрсөлдөөн

19 дүгээр зууны эцэсгэхэд Монгол оронмаань эдийн засаг, үйлдвэрлэлийн ямар нэгэн суурь баазгүй, эдийн засаг нь бараг л цор ганц бэлчээрийн мал аж ахуйгаас бүрдсэн, хил залгаа Орос, Хятад болон бусад орны мал, түүхий эдийг ханган нийлүүлэгч төдий хоцрогдсон эдийн засагтай орны нэг байлаа. Ийм нөхцөлд манай улсын зах зээлийг эзлэх, эдийн засгийг өөрийн эрхшээлд авахын тулд гадаадын орнууд өөрсдийн банк байгуулах тэмцэл, өрсөлдөөнийг бий болгож байжээ. Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, Манжийн дарангуйллаас Монгол улс чөлөөлөгдсөн 1911 оны үед тэдэнд төлөх өрийн хэмжээ 15.0 сая алтан рубльд хүрээд байжээ. Энэ үед Монгол оронд өөрийн үндэсний банк байгаагүй бөгөөд харин Орос, Хятадын болон гадаадын банкууд ажиллаж мөнгөн гүйлгээ эрхэлж эхлээд байлаа. 1900 онд Өргөө, Улиастайд хоёр салбартай Орос-Хятадын банк, мөн Хятадын Да цин банк болон 1914 онд Богд хааны зарлигаар Орос Сибирийн худалдааны банкны салбар “Монголын үндэсний банк” нэртэйгээр 1915 оноос 1919 он хүртэл тус тус ажиллаж байсан баримт байна. Монгол улсын Засгийн газраас улсынхаа эдийн засгийн бие даасан байдлыг бий болгохын тулд санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, мөнгө, зээлийн тогтолцоог бүрдүүлэх, гадны санхүүгийн капиталыг хязгаарлах шаардлага зүй ёсоор урган гарч байв.

1918 оны сүүлчээр нээгдсэн Хятадын Жунго банкны салбарыг Сю Шү Жан 1919 оны сүүлээр татан буулгаж, Япон, Хятадын хувь нийлүүлсэн Жибин банкны салбарыг оруулж ирсэн нь ч удалгүй үйл ажиллагаагаа зогсоож байжээ.

Монгол орны нийгэм эдийн засгийн хоцрогдол, валют, мөнгөний тогтвортой гүйлгээгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан дээрх банкууд удаан хугацаагаар ажиллаж чадахгүй 1-2 жил болоод үйл ажиллагаа нь зогсоход хүрч байсан байдаг. Түүнчлэн манайд үндэсний валют байгаагүйгээс гадаадын хэд хэдэн орны валют манай орны зах зээлд гүйж байлаа.

1912 онд Орос, Монгол хоёр улсын худалдааны гэрээгээр Оросын пүүс, хоршоод түрээс хураалгахгүйгээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой болсон нь тус улсын мөнгө, санхүүгийн бүх асуудлыг мэдэлдээ авах, улмаар өөрийн эрх ашигт нийцсэн банк байгуулах нөхцөлийг бий болгохоор зорьж эхэлжээ.

Мөн онд Оросын харъяат Юфермов гэгч Англи, Францын пүүстэй хувь нийлүүлсэн ДИУ банк байгуулах албан ёсны зөвшөөрлийг Богд хаант Монгол улсаас авсан анхны хүн нь болж байв. Орос улс ч ДИУ банкнаас өрсөхийн тулд 1915 онд багтаан Монгол цаасан мөнгө болон зоос гаргах эрхтэй “Монгол улсын сангийн банк” гэгчийг байгуулж, Монгол орны албан хэрэгцээнд зориулж жилд 6 хувийн хүүтэй зээл олгож байх, банкны жил тутмын цэвэр ашгийн 14 хувийг Монголын Засгийн газарт шилжүүлж байхаар тохиролцсон байдаг. Гэвч уг банк гэрээгээ зөрчиж, цаасан мөнгө, зоос үйлдэж гүйлгээнд огт гаргасангүй, өөрөөр хэлбэл тус банк зөвхөн хувь хүн, пүүс, хоршоонд мөнгө зээлдүүлж, хүүгээс нь үлэмж хэмжээний ашиг олж л байжээ. 1918 оны 10 дугаар сарын 14-нд ДИУ банкнаас Монгол улсад банк байгуулах талаар Засгийн газартай 14 зүйл гэрээгээр тохиролцож, түүний салбарыг Хиагт, Улиастай, Ховд хотод нээхээр болж, ДИУ банкны Мөнгөн тэмдэгт цаасыг гүйлгээнд чөлөөтэй хэрэглэхийг Засгийн газраас нийтэд ухуулан зарлаж байсан байна. Тухайн үед Монгол улсын Засгийн газрын бодлого нь Монгол улсыг Тусгаар тогтносон, бие даасан улс болгохыг Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэх, Орос улсаас улс төрийн болон эдийн засгийн дэмжлэг авахыг эрмэлзэж байлаа.

Монгол орны нийгэм, эдийн засаг туйлын хоцрогдонгүй, улс төр нь тогтворгүй байсан үед манай орны зах зээлийг эзлэн авах, Монгол орныг өөрийн эрхшээлд татан оруулахын тулд Орос, Хятад болон бусад орнууд өөрсдийнхөө банкныг байгуулах өрсөлдөөн хүчтэй байсныг дээрх түүхийн баримтууд гэрчилж байна.

Гэвч эдгээр банкуудын үйл ажиллагаа Монгол орны нийгэм эдийн засгийн хоцрогдол, валют, мөнгөний тогтвортой гүйлгээгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан удаан хугацаагаар ажиллаж чадахгүй 1-2 жил болоод үйл ажиллагаагаа зогсоож байжээ. Монгол Улсад өөрийн үндэсний банк байгаагүйгээс гадаадын хэд хэдэн орны валют Монгол орны зах дээр гүйгдэж байлаа.

Монголын зах зээлд 1830 онд Хаант Оросын анхны пүүс орж ирээд удалгүй Ховд, Улиастайд Оросын худалдааны пүүсүүд ажиллаж байжээ.

Монголд өөрийн үндэсний банк, мөнгөн тэмдэгт байхгүй үед хаант Оросын банкны салбар хоёр удаа, Хятадын банкны салбар гурван удаа байгуулагдаж байснаас гадна Хятадын банкнаас паяз нэртэй цаасан мөнгийг гурванч удаа гаргаж байжээ. Энэ үед Монгол Орос,

Хятадын зоос, цаасан мөнгө гүйгдэж байсны хамт Испани, Мексик, Англи, Америкийн доллар Германы Марк, Японы иен зэрэг гадаадын мөнгөн зоос гүйлгээнд явж байсан байна. XIX зууны эцэс XX зууны эхээр Монгол оронд гадаадын 5000 орчим худалдааны байгууллага, цэг, салбарт 2000 шахам худалдаачид ажиллаж байсны ихэнх нь хятад худалдаачид байжээ. Тэдний мөнгөний эргэлт 15-20 сая мексик долларт хүрч байсан баримт байна. Монголд өөрийн үндэсний банк, мөнгөн тэмдэгт байхгүй үед хаант Оросын банкны салбар хоёр удаа, Хятадын банкны салбар гурван ч удаа байгуулагдаж байснаас гадна Хятадын банкнаас пязоз нэртэй цаасан мөнгийг гурван ч удаа хэвлэн гаргажээ. Энэ үед Монгол, Орос, Хятадын зоос, цаасан мөнгө гүйгдэж байсны хамт Испани, Мексик, Англи, Америкийн доллар, Германы марк, Японы иен зэрэг гадаадын мөнгөн зоос гүйлгээнд явж байсан байна. 19 дүгээрзууны сүүлч 20 дугаар зууны эхээр манай оронд гадаадын 5000 орчим худалдааны байгууллага, цэг, салбарт 2000 шахам худалдаачид ажиллаж байсны ихэнх нь хятад худалдаачид байжээ. Тэдний мөнгөний эргэлт 15.0-20.0 сая мексик долларт хүрч байсан баримт байна. Ийм нөхцөлд Богд хаант Монгол улсын Засгийн газар өөрийн мөнгөн тэмдэгттэй болох зорилго тавин ажиллаж эхэлжээ. Монгол улсын Засгийн газар 1921 оны 4 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 20 хүртэл 6 сарын хугацаатай цаасан мөнгийг гүйлгээнд тодорхой хэмжээгээр хэвлэн гаргажээ.

Энэ мөнгөн тэмдэгтийг малаар баталгаажуулж “бага болзоот” хэмээн нэрлэсэн байдаг. Бага болзоот нь 10, 25, 50, 100-тын дэвсгэртээр модон бараар хэвлэгдсэн байна. 10-тын дэвсгэрт нь хонины, 25-тын дэвсгэрт нь үхрийн, 50-тын дэвсгэрт нь морины, 100-тын дэвсгэрт нь тэмээний зурагтай ба хэвлэсэн газар, он, сар, өдөр, тамга тэмдэг гарын үсэгтэй юм. Мөн 1924 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Засгийн газрын 32 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд “Засгийн газрын сангийн яамнаас Монголын 11 дүгээр он (1921) ЗСБНХОУ-ын сангийн яам лугаа хэлэлцэж, харьяат улсын сангаас гаргаж, зарцуулах мөнгөн тэмдэгт цаас гурван сая таван түмнийг хэвээр хадгалж буйг” эдүгээ авчруулж, харьяат санд буй мөнгөний хэр зэргээр гаргаж зарцуулбаас аливаад тус дөхөмтэй болохын дээр, ашиг орлого нэмэгдэх зүйл буй гэжээ. Гэвч энэ мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулаагүй байдаг. Учир нь уг дэвсгэрт нь тухайн үеийн Сангийн сайд С.Данзангийн гарын үсэгтэй гарсан байснаас "С.Данзан нь доллар шүтсэн хөрөнгөтний талыг баримтлагч" хэмээн баривчлагдаж, цаазлагдсантай холбоотой ажээ. Энэ үед үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулах, мөнгөн гүйлгээг цэгцлэх явдал шинэ дутам байгуулагдсан Монгол улсын Засгийн газрын өмнө тавигдсан гол зорилтуудын нэг байв. Энэ нь тус улсад үндэсний банк байгуулах явдал байлаа.

Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк) байгуулагдсан нь

Олноо өргөгдсөний 12 дугаар оны (1922 он) 2 дугаар сарын 27-нд Монгол ёсны цагаан сар тохиожээ. Эл өдрийн маргааш нь аргын тооллын 28, усан нохой жилийн хаврын эхэн сарын шинийн хоёрны өдөр хуралдсан Монгол улсын Засгийн газрын түр хурлаар “Хоршоо сайжруулах банк” нээх шийдвэр гаргаж, тус банкны дүрэм боловсруулах болсон байна. 1923 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Монголын худалдаа ба аж үйлдвэрийн

банк(Монголбанк)-ны дүрэм батлагдаж, Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк) үүсгэн байгуулах, хувь нийлүүлэгчдийн хурал, 1924 оны 4 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд Монголын нийслэл Өргөө хотноо болсон байна. Энэхүү хурлаар Банкны зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголын талаас Ренчино Элбэгдорж, Дорж мэйрэн, Жамсран, Жадамбаа, Орос улсын талаас Васильев, А.Н. Бемий, Шастин П.Н нарын 7 хүнийг оролцуулжээ. Банкны зөвлөлийн даргаар Васильев, Ренчино Элбэгдорж нарыг, зөвлөлийн орлогч гишүүдэд Баянчуулган, Намсрай, Даваа, Юдин В.И, Даниана В.Г, ерөнхий хорооны гишүүдэд Комор Валентин Иосифович (дарга-орос I), Шур Г.Н, Берлацкий Б.М, Цэдэн-иш, Бат-очир, Шалган байцаах комиссын гишүүд Мерийн В.Я, Довдонов, Нямаа, Шалган байцаах комиссын орлогч гишүүн Канушевский нарыг оруулжээ. Банкны зөвлөлөөс банк байгуулах бэлтгэл ажлыг хийж дууссан учир олноо өргөгдсөний 14 дүгээр он буюу аргын тооллын 1924 оны 6 дугаар сарын 02-ны билэгт сайн өдөр Монгол Оросын хувь нийлүүлсэн Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк)-ыг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн түүх ийм. Монгол Оросын хувь нийлүүлсэн банк(Монголбанк)-ны хувь хөрөнгө(дүрмийн сан)-ийг 500,000.0 төгрөгөөр тогтоож, Монгол Оросын Засгийн газар тэнцүү хэмжээгээр тус бүр 250,000.0 төгрөгөөр бүрдүүлсэн байна. Тус банкиг Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) хэмээн нэрлэхээр шийдсэн байна. Банкны анхны салбарыг Орос Монголын хил дээрх Алтанбулаг сууринд нээж, банкны анхны тэнцэлд кассын анхны гүйлгээг 11.7 сая янчаан, Улс ардын аж ахуйд олгосон зээл 25.4 мянган янчаан хэмээн тусгасан байдаг. Тус банкны дүрмээр үйл ажиллагааг нь дэлгэрэнгүй зааж, мөрдүүлснээс дурьдвал: Банкны дүрмийн 1 дүгээр зүйлд банкны үүрэг зорилтыг “Банк болбоос Монгол ард улс ба СССР (Зөвлөлт холбоот улс)-ын хооронд эдийн засгийн талаар харилцах явдлыг бататгах, Монгол улсын худалдаа ба аж үйлдвэрийг хөгжүүлэх хэрэг дор туслах, басхүү Монгол улсын мөнгөний гүйлгээг бататгах зорилго буй” гэж тодорхойлжээ. Үүнээс үзэхэд Монголбанк нь тухайн үеийн Монгол ард улс, Зөвлөлт холбоот улсын эдийн засгийн хамтын ажиллагааг бататган хөгжүүлэх, манайд шинэ тутам байгуулагдаж байсан үндэсний худалдаа, аж үйлдвэрийг хөгжүүлэхэд мөнгө зээлийн гүйлгээгээр дамжуулан туслах, тус оронд үндэсний мөнгөн тэмдэгтийг бий болгож, түүнийг бат тогтвортой хөгжүүлэх зорилготой байсан байна.

Монголбанк байгуулагдсан өдрөөсөө эхлэн Үндэсний мөнгөн тэмдэгтэй болж, мөнгөний шинэчлэл хийх ажлыг эрхэм зорилт болгон хэрэгжүүлж эхэлсэн байдаг. 1924 оны 9 дүгээр сард хуралдсан БНМАУ-ын анхдугаар их хурлаас мөнгөний шинэтгэл хийж, эдийн засгийг бэхжүүлэх талаар удирдамж чиглэл болох ач холбогдол бүхий шийдвэр гаргажээ.

Монгол орны зах зээл дээр гүйгдэж байсан Орос, Хятадын болон гадаад бусад орны мөнгөн тэмдэгт, мөнгөний оронд арилжаалагдан солилцож байсан цагаан мөнгө, цай, хадаг зэрэг эд агуурсыг зах зээлээс шахан гаргаж, улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг бататгах нь улс төр, нийгэм эдийн засгийн бие даасан байдлыг хангах явдал гэж дүгнээд Монголбанкнаас цаашид хэрэгжүүлбэл зохих эн тэргүүний зорилтыг мөнгөн гүйлгээний системтийг шинэтгэх,

ийм учраас үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулж, цоо шинэ эдийн засгийг буй болгох явдал гэж үзэж байсан байна.

Мөнгөн гүйлгээний гол хэрэгсэл болж байсан цагаан мөнгө, Монголын зах зээл дээр хэдий хэмжээтэй байсан, ямар хэмжээтэй хил гаалиар орж, гарч байсан нь тодорхойгүй байжээ. Монголчууд цай, тамхи, даалимбуу зэрэг бөс бараагаар хэрэгцээгээ хангахын тулд эд барааг, мал аж ахуйн гаралтай түүхий эдээр солилцон авч, өгөлцдөг байлаа. Гэтэл иргэдийн хэрэглэдэг цай, тамхи, гурил будаа, хувцас хийдэг бөс бараа нь тэдний өдөр тутмын хэрэгцээ болж байхад түүнийг хятад худалдаачдаас сольж(арилжиж) авдаг малын гаралтай түүхий эд нь улирлын чанартай, Тухайлбал, хавар, зун нь ноос ноолуур, намар, өвөл нь арьс шир мал, мах зэрэг түүхий эд бэлэн болдог байсан учир иргэд өдөр тутмын хэрэгцээгээ хангахын тулд дээрх барааг хятад худалдаачдаас өр тавьж, өндөр хүүтэй зээлээр авдаг явдал ёс мэт тогтсон байжээ. Үүнээс үүдэн Монголчууд хятадын пүүс, худалдаачдад төлөх өрийн хэмжээг дааж төлөхөд бэрхтэй, мөлжлөгийн чанартай болж эхэлсэн байдаг. Энэ тухай Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк)-наас гаргасан тайланд “Ийм өр хэтэрхий их болж арван тав, хорин саяд илүү дор хүрч байсан буй” хэмээн тэмдэглэсэн байна. Энэ бол Монголбанкнаас үндэсний мөнгөн тэмдэгттэй болох зөвхөн нэг шалтгаан нь байсан юм. Нөгөө талаар манай улсын зах зээлд хятадын цагаан мөнгөнөөс гадна хятадын янчаан хэмээх мөнгөн тэмдэгт ихээр гүйлдэж байсан бөгөөд үүний зэрэгцээ оросын цагаан мөнгөн зоос, Червонз хэмээх цаасан мөнгө, бусад гадаад улсын мөнгөн тэмдэгт, мексик доллар, зэс, мөнгө бага хэмжээтэй гүйгдэж байлаа. Иймд манай улсад үндэсний мөнгөн тэмдэгт бий болгож, Ардын аж ахуйг өргөнөөр байгуулах, Улсын санхүүг сайжруулах, харилцан туслалцах хоршоог үүсгэн байгуулж хөгжүүлэх, мал аж ахуйг өсгөх, иргэдийн амьжиргааг сайжруулах нэн тэргүүний зорилт нь Засгийн газар мөнгөний шинэтгэлийг яаравчлан хийх шаардлагатай тулгарснаар тайлбарлагдана. Гэвч мөнгөний шинэтгэл хийж, Үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийх ажлыг машид болгоомжлон, нарийн чанд явуулах шаардлага тулгарч байлаа. Монголбанкны дүрэмд зааснаар тус улсын мөнгөн гүйлгээний шинэтгэлийг зүй зохистойгоор явуулахдаа тус банкинд ногдуулсан бусад үүргийн хамт банк байгуулагдсан цагаасаа эхлэн үлэмж анхаарал тавьж зохих хяналттайгаар хэрэгжүүлж иржээ.

Үндэсний мөнгөн тэмдэгттэй болсон нь

Монголбанк байгуулагдсанаас хойш банкны гүйлгээг хятадын янчаанаар жил гаруй хугацаанд хийж байгаад Монгол улсын Засгийн газрын 1925 онд гаргасан шийдвэрийн дагуу 1925 оны 12 дугаар сарын 8-нд 200,144 ширхэг цаасан тэмдэгт төгрөг, 1926 оны 02 дугаар сарын 4-нд цагаан мөнгөн зоосыг гүйлгээнд гаргажээ. Ингэснээр Монголын үндэсний валют болох цаасан тэмдэгтийг төгрөг, мөнгөн зоосыг мөнгө хэмээн нэрлэн, нэг төгрөг 100 мөнгөтэй тэнцэж байх нэгжийг бий болгожээ.

Төгрөг гүйлгээнд гаргасан анхны өдөр нэг төгрөгийн агуулга нь 18 грамм цалин цагаан мөнгө байсан ба 0.88 хятад янчаантай тэнцэж байв. Монголбанк төгрөгийг гүйлгээнд гаргасны дараа Монголын өргөн дэлгэр газар нутаг, хот, сум, тэрчлэн малчин ард олонд хятад янчаан багагүй

байсан, янчаанд ард олон нилээд дасч, арилжаа наймаанд өргөн хэрэглэж байсан болон янчааний үнэ ханш, гүйлгээнд шинээр орсон үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөс өндөр байсан учир төгрөгийг бэхжүүлж, янчаанийг гүйлгээнээс хасах шаардлага тулгарч байжээ. Иймд нэг хэсэг хугацаанд төгрөг янчаантай өрсөлдөн гүйлгээнд явж байсны дээр жил, сар өнгөрөх дутам төгрөгийн үнэ цэнэ өсч, янчаанийг гүйлгээнээс хасах явдал улам нэмэгдэх болж, Монголын иргэд үндэсний валют төгрөгийг бэхжүүлэх, төгрөгөөр худалдаа хийх явдлыг сайнаар хүлээн авч байсан учир 1928 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хятад янчаанийг гүйлгээнээс бүрэн хасах шийдвэр гаргаж, зах зээлээс ангижруулж чадсан байна.

Энэ өдрөөс эхлэн мөнгөний шинэтгэлийн анхны шат дуусч тус улсын дотор мөнгөний гүйлгээг гагцхүү төгрөгөөр гүйцэтгэх болжээ. Мөнгөний гүйлгээг шинэтгэх явцад тус улсын мөнгөний гүйлгээ ямагт нэмэгдэж ирсэн байна.

Монгол улс байгуулагдсанаас хойш 7 жилийн дотор гүйлгээнд гаргасан төгрөг 11,473,000.0 хүрсэнээс мөнгөн тэмдэгт цаасан төгрөг 9,079,000.0 зоосон төгрөг 2,032,000.0 жижиг цагаан мөнгөн зоос(мөнгө) 333,600.0 төгрөг, зэс зоос 28,600.0 төгрөг болжээ. Энэ үед мөнгөн гүйлгээнээс хураасан янчаан таван сая илүү, бусад улсын мөнгө таван зуун мянга бие мөнгө 350,000.0 болсон байна. Энэ нь Монголбанк гадаадын мөнгийг гүйлгээнээс татаж өөрийн үндэсний мөнгө, төгрөгөөр үндсэнд нь сольж чадсаныг харуулж байна. Энэ үеэс эхлэн Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн үнэ, цэнийг нэмэгдүүлэх, цаашид бат тогтвортой хөгжүүлэх үүднээс төгрөгийг алтан баталгаанд шилжүүлэх зорилт тавьсан байна. Үүнийг Монголбанкнаас мөнгөний шинэтгэл хийх хоёрдугаар үе эхэлсэн гэж үзэж байлаа. 1927 оны 11 дүгээр сард болсон Монгол улсын Ардын их хурлын 4 дүгээр хуралдаанаас “мөнгөний шинэтгэлийг цаашид үргэлжлүүлэн төгрөгийг алтан баталгаанд шилжүүлэн эх орны нутаг дэвсгэр дээр гадаад валютыг гүйлгээнд авахыг зогсоох арга хэмжээ авах” чиглэл өгсөн байна.

Төгрөгийг Алтан баталгаанд шилжүүлсэн нь

Төгрөгийг алтан баталгаанд шилжүүлэх үндсэн шалтгаан нь манай орны зах зээл дээр гүйгдэж байсан хятад янчаан нь цагаан мөнгөөр батлагдан, солилцож байсан учир Монгол төгрөгийг хятад янчаанаас илүү үнэ цэнэтэй, өндөр ханштай болгох шаардлагатай байжээ. Энэ нь алт аль ч улсад өндөр үнэтэй байдаг тул гадаад орнууд ч төгрөгийг алтан баталгаанд шилжүүлвэл хүлээн авах боломж өндөрсөх учиртай байлаа. Энэ талаар Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 1927 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төгрөгийн 17 хувийг алтаар баталж, үлдэх 83 хувийг нь цалин цагаан мөнгө болон түргэн борлогдох бараагаар баталгаажуулсан байна. Төгрөгийг алтаар баталгаажуулах явдлыг цаашид улам улмаар нэмэгдүүлж, 1928 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төгрөгийн 40 хувийг, мөн оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 64 хувийг, 1928 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 100 хувь алтан баталгаанд шилжүүлж, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг нь цэвэр алтаар бүрэн баталгаажих болсон байна. Энэ өдрөөс эхлэн манай улсад хийсэн мөнгөний шинэтгэлийн хоёрдугаар үе шат бүрэн хэрэгжсэн гэж үздэг.

Мөнгөн гүйлгээний шинэтгэлийн нэгдүгээр үе нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг шинээр гүйлгээнд оруулж, Монголын зах зээлийн төлөө янчаантай өрсөлдөж байсан үе мөн.

Хоёрдугаар үе нь төгрөгийг алтан баталгаанд оруулж, Монголын зах зээлд бат, тогтвортой байр суурь эзлэх болсон явдал байв. Энэ үеэс эхлэн төгрөг нь хууль ёсны төлбөрийн ганцхан хэрэгсэл болж дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдөж танигдсан валют болох нөхцөл бүрдсэн байна. Монголын зах зээлд хятадын янчаан хүчингүй болж, гүйлгээнээс бүрмөсөн шахагдан гарах болсон юм. Хятад янчаан олон жил Монголын зах зээлд ноёлж, өргөн олны гар дээр бага бус хэмжээтэй цугларсан байсан тул иргэдээс хятад янчаанийг хохирол багатай хураан авах шаардлага гарч иржээ.

Иймд 1928 оноос нэг янчаанийг 65 мөнгөтэй тэнцүүлэн Монголбанк худалдан авч эхэлсэн байна. Ингэж үндэсний валют төгрөгийн үнэ цэнэ өсч, иргэдийн итгэл хүлээснээр мөнгөний шинэтгэл хийх Монгол улсын Засгийн газар, Монголбанкны үүрэг бүрэн хэрэгжсэн учир дараагийн шатанд мөнгөний нөөц эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой болсон юм.

Монголбанк байгуулагдан ажил гүйлгээгээ эхлэн явуулахдаа 500,000.0 төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байсан нь төдийлөн их биш хөрөнгө байлаа. Ийнхүү өөрийн хөрөнгийн тал хувийг Монгол улс, нөгөө тал хувийг нь Зөвлөлт холбоот улсаас хувь нийлүүлсэн хөрөнгө байсан тухай дээр өгүүлсэн бөгөөд энэ үед өөрийн хөрөнгийг цаашид жил тутам нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор урган гарах шалтгаан болсноос, Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд банкны өөрийн хөрөнгийн хэмжээг янчаанаар тооцож тэнцэлд тусгаж байсан учир дүрмийн сан нь 1928 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн өөрийн хөрөнгийг төгрөгөөр тооцох болж дүрмийн сан нь 1,650,000.0 төгрөг болж, Монголбанкны өөрийн хөрөнгө байгуулагдсанаас хойш 3 жил 6 сарын хугацаанд 3.1 дахин өссөн байна. Түүнчлэн тус банк нь 1928 оны 7 дугаар сарын 01-нд 102,000.0 төгрөгийн бэлтгэл хөрөнгө, 210,000.0 төгрөгийн тусгай хөрөнгөтэй болж өөрийн хөрөнгийн хэмжээ 1,962,000.0 төгрөгтэй тэнцэх болсон байна.

Монголбанк харилцагч аж ахуйн нэгж, байгууллагад харилцах данс иргэдэд харилцах, хадгаламжийн данс нээж, мөнгийг хуримтлуулах ажлыг эрчимжүүлэх болжээ.

Банк нь мөнгө зээлдэх, зээлдүүлэх үүргээ биелүүлэх зорилгоор бусдын чөлөөт мөнгөн хөрөнгөнд хүү төлөх замаар хадгаламжид авч зээлдүүлэх мөнгөний эх үүсвэрийг хуримтлуулах замаар зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж байв.

Аж үйлдвэр, хоршоо, худалдаа, авто тээвэр зэрэг шинэ дутам байгуулагдаж байсан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад үйл ажиллагаа явуулахын тулд мөнгөн хөрөнгийн хэрэгцээ үлэмж их байсан нь тодорхой бөгөөд нөгөө талаар иргэдийн өргөн хэрэглээний барааны хангамжийг сайжруулах шаардлага их байжээ. Ийм нөхцөлд банкны зээл чухал шаардлагатай болсон бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээ, хангамж нь хараахан бүрдээгүй сул чөлөөтэй мөнгөн хөрөнгө байсаар байгаа нь банк зээлийн эх үүсвэр бүрдүүлэх, хадгаламж авч мөнгөн хөрөнгийн нөөцөө арвижуулах боломжтой болж ирсэн байна.

Энэ үед банк зээлийн эх үүсвэр болох аж ахуйн нэгж, байгууллагын харилцах, иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэхийн тулд ихээхэн анхаарч шуурхай ажиллаж байлаа. Үүний үр дүнд аж ахуйн нэгж, байгууллага бүхэн банкинд харилцах данс нээж, банкаар дамжуулан гүйлгээ хийх болсон байна. Иргэдэд сул чөлөөтэй мөнгөө банкинд хадгалуулахын ач холбогдлыг өргөн тайлбарлаж таниулснаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл ч нэмэгдэж байжээ. Банкнаас хадгаламж эзэмшигчдэд тодорхой хэмжээний хүү бодож олгох болсон нь үр дүнгээ өгсөн байна. Хадгаламж эзэмшигчдэд хадгаламжийн хүү бодож олгохдоо хадгалуулсан хугацааг харгалзан харилцан тохиролцож, нэг жилийн хугацаанд хадгалуулбал нэгэн зуун төгрөг дутмаас 4 хувийн хүү бодож олгоно. Хэрвээ нэг жилийн хугацаанд хүрэхгүй бол хадгалуулсан хоног, сар, улиралд ногдох хүүг банк тооцож олгодог журам тогтоожээ. Иргэдээс банкны хадгаламжид мөнгөө хадгалуулах явц удаан байсан, хадгалуулсан ч бага хэмжээтэй байсан тул хадгаламжийг 4 хувийн хүүтэй болгон түүнийхээ ач холбогдлыг “мал удах тусам төллөн хоёр болдогийн адил хадгаламж, хугацаа удах тусам хүүгээр үржиж, нөхөн төлжинө” хэмээн тайлбарлан таниулж байсан нь хадгаламжийн ач холбогдлыг нь ойлгоход дөхөм болж байсан байдаг. Аймаг орон нутагт банкны салбар цөөн байсантай холбоотой банкны учир холбогдлыг иргэд ойлгох нь удаан байсан ч банкнаас зохиосон ажлын үр дүнд банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1928 оны 7 дугаар сарын 01-нд 6,692,859.0 төгрөг болсон нь энэ үеийн банкны өөрийн хөрөнгөнөөс 3 дахин нэмэгджээ.

Мөнгө хадгаламж эзэмшигчид хадгаламжаасаа мөнгө авахад нь элдэв зүйлийг асууж шалгаахгүйгээр шууд мөнгийг олгож байх журам үйлчилж байв. Энэ нь бичиг үсэггүй болон муу мэддэг хүмүүст чирэгдэлгүй хадгаламж эзэмшүүлэх зорилготой байжээ.

Түүнчлэн хадгалуулах мөнгөний доод дүнг тогтоогоогүй нь бага боловч мөнгийг хадгаламжид авах, хадгаламжид төлөх хүүг жил дутам 6 хувь болгож, нийт хадгаламж эзэмшигчдээс 2 хувиар илүү байхаар нэмэгдүүлэн тогтоосон нь хадгалуулагчдад хүүгээр ашиг олох боломж олгож, хадгалуулагчдын тоог нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болжээ.

Хадгалуулагчдад төлсөн хүүгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байв. Тухайлбал 1928 оны эхний 6 сард хадгаламжийн хүүд 120,000.0 төгрөг төлсөн нь 1927 оны бүтэн жилд төлсөн 82,000.0 төгрөгийн хүүгээс 46 хувиар их байна.

Хадгаламж эзэмшигчдээс хадгалуулсан мөнгөний хэмжээ 1928 оны 01 дүгээр сарын 01-нд 174,000.0 төгрөг байсан бол 6 сарын дараа буюу 1928 оны 7 дугаар сарын 01-нд 1,228,800.0 төгрөг болж 1.0 сая гаруй төгрөгөөр нэмэгдсэн байна. Жижиг хадгаламжид төлсөн хүү нь харилцах дансны үлдэгдэлд төлөх хүүгээс үлэмж их байгаа нь иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэх зорилготой байжээ. Банкны хувь хөрөнгө(өөрийн хөрөнгө), бусдын харилцах данс, жижиг хадгаламжид хадгалуулсан мөнгө нь аж ахуйн нэгж, иргэдэд олгох зээлийн гол эх үүсвэр болж байлаа.

Монголбанк өөрийн хөрөнгө болон зээлдүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд Зөвлөлт холбоот улсын Даль банк, болон Зөвлөлт холбоот улсын Улсын банкнаас бага хүүтэй зээл авч

байсан байна. Эдгээр банкнаас авсан зээлийн хэмжээ 1928 оны 07 сар гэхэд 1,500,000.0 төгрөгт хүрчээ. Мөн Монголд байсан Зөвлөлт холбоот улсын худалдааны байгууллагад зээл олгоход зориулан тусгай хөрөнгө, сан байгуулж байв.

Улсын банк байгуулагдах нөхцөл бүрэлдсэн нь

1950-аад онд Монголын эдийн засагт бага бус өөрчлөлт гарч, Үндэсний аж үйлдвэр, тээвэр, холбоо, барилга, худалдааны шинэ салбарууд бий болж, үйл ажиллагаа нь бэхжиж, санхүү зээл, мөнгөн гүйлгээний салбарт гүнзгий өөрчлөлт гарсан байна. Үүнтэй уялдан 1946 онд Улсын бага хурлаас аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэр аж ахуйн газруудын тооцооны ба харилцах данснаас төлбөр гүйцэтгэхдээ тодорхой ээлж дараалал баримтлах тухай хууль батлан гаргажээ. Ингэснээр үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагын тооцооны болон харилцах данснаас тэргүүн ээлжинд цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах төлбөрийг төлсний дараа, санхүү, зээл, даатгалын төлбөр, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн нэхэмжлэлийг гүйцэтгэх болж үүнийг данс нээлгэсэн банк хариуцан шууд данснаас нь уг төлбөрийг гүйцэтгэдэг болжээ. Энэ нь банкны үйл ажиллагааны цар хүрээ өргөжин бэхжиж ирсэнийг харуулж байна. Улс ардын аж ахуйн хөгжлийн дагуу банк өмнөө тавигдсан зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, энэхүү салбарыг зээл, мөнгөн гүйлгээ, төлбөр тооцоо, хөрөнгө оруулалт санхүүжилт зэрэг үндсэн үүргээр бие даан хэрэгжүүлэх үндэс бүрдэн, урт болон богино хугацаатай зээл олгож, төлүүлэх ажилд чанарын өөрчлөлт гарч, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хоорондын тооцоог эрхлэн гүйцэтгэж, зээл, мөнгөн гүйлгээний ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх нөхцөл бүрджээ. Ийнхүү Монголбанк өөрийн хөрөнгө болон үйл ажиллагааны талаар бүрэн бэхжиж, улс ардын аж ахуйн тооцооны нэгдсэн төв, зээл мөнгөн гүйлгээг эрхлэн гүйцэтгэх цорын ганц байгууллага болон бэхэжсэн болно. Монголбанкны ажил, үйлчилгээ өргөжин тэлж аймаг бүрт харьяа хэлтэстэй, томоохон төвлөрсөн сум, суурин газруудад салбартай болж, Монгол улсын нутаг дэвсгэр даяар хүрч үйлчлэх боломж нөхцөл бүрджээ.

Эхний үед эдгээр хэлтсүүдэд 3-5 ажилтны орон тоотой Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк)-ны хэлтэс нэртэй байв. Боловсон хүчний хувьд бэхжиж Үндэсний мэргэжлийн боловсон хүчнээр үйл ажиллагаагаа явуулах бололцоотой болж эхэлсэн байна. Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк) анх байгуулагдаж байсан 1924 онд ердөө 22 ажилтантай байсны 18 нь Орос, 4 нь Монгол ажилтан байсан бол 1954 онд Банкны хэлтэс 22, касс 13 болж , Орос зөвлөх 4, Монгол ажилтан 414 болж бэхэжжээ.

Тухайн үед Монгол улсын Улсын банк байгуулах бодит нөхцөл, боломжийг нээж өгсөнөөрөө Монгол Оросын хамтарсан Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк)-ны түүхэн ач холбогдол оршино.

Чухам энэ үе(1924-1954 он)-д Монгол улсын банкны салбарт дор дурдсан шинэ нөхцөл, боломжууд бүрдсэн байдаг. Үүнд:

1. Монгол улсад үндэсний мөнгөн тэмдэгтийг бий болгож, төгрөгийн үнэ ханшийг тогтворжуулан Алтан баталгаанд шилжүүлсэнээр нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн валют болсон.

2. Мөнгөний гүйцэтгэх үүрэг, зарчмыг цоо шинээр хэрэгжүүлж, бэлэн бус тооцооны хэлбэр агууллагыг улс ардын аж ахуйн салбар бүрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх заавар, дүрэм, хууль тогтоомж гаргаж, хэрэглэх маягтыг хүртэл Монголын онцлогт тохируулан бий болгосон.

3. Зээл, түүний зарчим, хүү, эргэн төлөгдөх хугацаа, баталгаа авах, барьцааг тооцох, төлбөрт авах арга хэлбэрийг бий болгосон.

4. Хөрөнгө оруулалтын санхүүжилт, урт хугацаат зээл олгох, хугацаа тогтоох арга ажиллагаа нь цаашид банкны ажилд хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгосон.

5. Монголбанкинд ажиллах үндэсний мэргэжлийн боловсон хүчнүүдийг бэлтгэхийн тулд Оросын банкны мэргэжлээр мэргэшсэн ажилтнуудыг дагалдуулан сургаж, цаг, минутаар хэмжигддэг өдөр тутмын тайлан гаргахаас эхлээд бүх ажлыг нягт нямбай цаг алдалгүй хийхийг заан сургаж, банкны цоо шинэ нөхцөлд үндэсний боловсон хүчин, мэргэжлийн ажилтнуудын нөөцийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

6. Банкны салбар, хэлтэс, тооцооны кассыг улс орны өнцөг булан бүрт байгуулж, банкны үйлчилгээг бий болгосон зэрэг нь Монгол улсад Үндэсний өөрийн банк байгуулах нөхцөл байлаа.

Ингэж хувь нийлүүлсэн Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк) байгуулагдан ажилласнаар Монгол улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд банкны гүйцэтгэх үүрэг, хариуцлага, ач холбогдол нь улам бүр тодорхой болж, боловсон хүчнүүд нь бие даан цаашид үргэлжлүүлэн ажиллах бүх талын нөхцөл боломж бүрэн бүрэлдсэн учир Зөвлөлт холбоот улс тус банкинд оруулсан хувь хөрөнгөө Монголын талд шилжүүлэн өгсөнөөр Улсын банк цоо шинээр байгуулагдах бус харин 1924 оноос эхлэн 30 гаруй жил ажиллаж ирсэн тэрхүү банкны үйл ажиллагааг үргэлжлүүлэн ажиллах нөхцөл боломжийг бий болгосон гэж үздэг.